

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны ~~02~~ сарын ~~17~~ -ны өдөр

Дугаар ~~67-054/2025~~

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 10 давхар 1 блок, 28 (хорин найм) автомашины дулаан зогсоолтой, 98 (ерэн найм) байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2017/07/21 огноо; 0000369/93/2017 дугаар; 2019/06/19 огноо; 0004220/222/2019, 00882 БА32024/0432 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: КК-03/22,

2.3. Захиалагч: Ви Эйч энд Би ХХК оноосон нэр, 9011089142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5148618 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны зам гудамж, 62 байр, А-1608 тоот, 99040999 холбоо барих утас, vhandb3@gmail.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Ви Эйч энд Би ХХК оноосон нэр, 9011089142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5148618 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны зам гудамж, 62-р байр, А-1608 тоот, 99040999 холбоо барих утас, vhandb3@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Кон Консалтинг ХХК оноосон нэр, 9011225131 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2651998 регистрийн дугаар, ЗТ16-186/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, Твин Тауэр-2, 902 тоот, 99116654 холбоо барих утас, conconbjv@gmail.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ви Эйч энд Би ХХК оноосон нэр, 9011089142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5148618 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

зам гудамж, 62 байр, А-1608 тоот, 99040999 холбоо барих утас, vhandb3@gmail.com
цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 10 давхар 1 блок, 28 (хорин найм) автомашины дулаан зогсоолтой, 98 (ерэн найм) байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;


б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.



3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 8 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 26 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 10 давхар 1 блок, 28 (хорин найм) автомашины дулаан зогсоолтой, 98 (ерэн найм) байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборын зориулалттай барилга барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 11 дугаар хороо, Ви Эйч энд Би ХХК-ийн захиалгатай, зорьтой 10 давхар 1 блок, 28 (хорин найм) автомашины дулаан зогсоолтой, 98 (ерэн найм) байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолбор

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Ви Эйч энд Би ХХК-ийн Захирал



(А.Мөнгөн)

(Г.Ванчинхүү)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, ВИ ЭЙЧ ЭНД БИ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ,
ЗООРЬТОЙ 10 ДАВХАР 1 БЛОК, 28 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 98
БАЙР СУУЦ БҮХИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОРЫН БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Ви эйч энд би ХХК-ийн захиалгатай, зоорьтой 10 давхар 1 блок, 28 автомашины дулаан зогсоолтой, 98 байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборыг ашиглалтанд оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 11:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12:30 цагт дуусав.

Хуралд:

- | ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР | |
|---|-------------|
| Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс | |
| 1. Хяналт шалгалтын газрын Барилга Байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Г.Батбаатар |
| 3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер | Ц.Билигт |
| 5. Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, ахлах инженер | Б.Оргил |
| 6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Д.Болормаа |
| 7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн Мэргэжилтэн | М.Жаргалан |
| 8. Онцгой байдлын ерөнхий газар, Зураг хяналтын тасгийн дарга, Дэд хурандаа | Б.Мягмаржав |
| 9. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн | О.Ундрах |
| 10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 11. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Дулаан хангамжийн инженер | Х.Очирбат |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Болормаа |
| 13. Зураг төсөл зохиогч Конконсалтинг ХХК-ийн архитектор | Б.Эгшиглэн |

14. Гүйцэтгэгч, Ви эйч энд би ХХК-ийн захирал

Г.Ванчинхүү

15. Захиалагч Ви Эйч энд Би ХХК-ийн захирал

Г.Ванчинхүү

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Ви эйч энд би ХХК-ийн захиалгатай, зоорьтой 10 давхар 1 блок, 28 автомашины дулаан зогсоолтой, 98 байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборыг ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар**:

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх
- Барилгад хэрэглэсэн арматурын шинжилгээг үзүүлэх
- Гадна тохижилт ногоон байгууламжийг ЗТ-ийн дагуу хийж үзүүлэх
- Заслын ажлыг бүрэн дуусгах фото баталгаажуулж
- Орцны цонхонд хязгаарлагч хийх
- Лифтний магадлал оруулсан дүгнэлт үзүүлэх
- Техникийн давхрын ус зайлуулах хоолойг доош нь буулгах
- Зоорийн давхрын авто зогсоолд будаг тэмдэг тэмдэглэгээ хийж үзүүлэх
- Үйлчилгээний хэсэгт 00-ийн өрөөнд ХБИ-ний зориулалтын тоноглол хийх
- 10-р давхрын 8 айл тагт төлөвлөөгүй ЗТЗ-гч, гүйцэтгэгч тайлбар ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

- Гадна дулааны худаг зургийн дагуу таг, шат, шугам будаж, дулаалга, өнгийн туузаар ороож стандартын дагуу янзлах
- Гадна дулаан, узель угсарсан ААН-ийн тусгай зөвшөөрөл шалгуулах, мөн фото акт шалгуулах
- Зоорийн давхрын түгээлтийн шугамын цэвэрлэгээ хийх
- Узелийн өрөөний шал, хана засал дуусгах
- Узелийн өрөөнд агааржуулалт, ус зайлуулах трап хийх

- Узелийн шугамуудыг зэврэлтээс хамгаалсан будаг, дулаалга, өнгөөр ялгах, хаягжуулалт хийх
- Халаалтын өргөх нацосны хүчин чадал зурагт тусгаснаас их байна. Угсарагдсан нацос ашиглалтын хэвийн нөхцөл хангах талаар автор, ашиглагч баталгаа гаргах
- Айлуудын дотор сан болон агаар сэлгэлтийн системүүдийн дутуу ажил, тоноглол гүйцэд угсрах
- Айлуудын босоо шугаманд үзлэгийн ревиз гаргах /00 өрөөнд/
- Дотор сан угсарсан /салхивч/ ААН-н тусгай зөвшөөрөл ил далд ажлын актууд шалгуулах
- Халаалтын коллекторын шугам будаж хаягжуулах /мөн тоолуурын/
- Нөөцийн савнаас ундны усны шинжилгээ өгөх, ариутгал хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер **Ц.Билигт:**

- Шинэ хэрэглэгчийн сүлжээнд холбох залгах зөвшөөрлийн бичиг
- Аянгын хүрээг гүйцээж хийх
- Цахилгааны самбарт хаягжуулалт, схем зураг хийх
- Узелийн өрөөний газардуулгын хүрээг гүйцээж хийх
- В1, В2, 1 давхрын гүйцэтгэлийн зураг гаргах
- Цахилгааны өрөөний газардуулгын хүрээг гүйцээж хийх
- Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13 заалтыг хэрэгжүүлэх
- Айлуудын дутуу монтажыг гүйцээх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, ахлах инженер **Б.Оргил:**

- Гадна дулааны холболтын цэг өөрчилсөн тухай албан тоотыг шалгуулах
- Дулааны холигч узелийн эргэлтийн нацос батлагдсан зургийн дагуу хүчин чадлыг бууруулж тавих
- Холболтын цэг өөрчилж авсан ХААИС-ийн ЦТП-н халаалтын бойлер, эргэлтийн нацос, даралт барих системийн хүчин чадлыг тооцож өргөтгөх
- Узелийн тоног төхөөрөмж хаягжуулалт хийх, дулаалга гүйцээх, засал хийж дуусгах
- Халаалтын дотор системийн өөрчлөлтийн зураг баталгаажуулах, нягтын шахалтын акт шалгуулах
- Халаалтын дотор системд термостат винтель суурилуулах, хуваарилах коллекторын хайрцаг бэхлэх
- УБДС ТӨХК-д үүрэг даалгаврын гүйцэтгэлийг албан тоотоор өгөх
- 2023 онд хийсэн аж ахуйн гэрээг шалгуулах, гадна шугам сүлжээг хотын мэдээллийн санд бүртгүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- УСУГ-с олгосон 655/22 тоот техникийн нөхцлийн хугацаа дууссан тул сунгуулах
- Гадна ЦБУ-ны далд ажлын акт баталгаажуулах
- Гадна БУ-ны худагт шат бэхлэж суурилуулах
- Нийслэлийн эрүүл мэндийн газарт усны шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах
- Гадна шугам сүлжээг хотын мэдээллийн санд бүртгүүлсэн зураг СД, акт үзүүлэх
- Барилгын урд талбайд цуглах борооны усыг бохир усны худагт нийлүүлэхгүйгээр зайлуулах систем төлөвлөх
- УСУГ-тай бохир ус татан зайлуулах гэрээ байгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **М.Жаргалан:**

- Давхрын самбарт хаяг бирк хийх
- Техникийн өрөөнд ил кабель далдлах
- Хяналтын камер, бичигч, домофон байнгын ажиллагаанд оруулах
- ХД КК-03/22 тоот зургийн дагуу дулаан мэдрэгчүүд бүрэн суурилуулах
- ХД гүйцэтгэлийн акт засаж дахин үйлдэх
- Гадна холбооны техникийн нөхцөл авч зураг сувагчлалыг угсралтын ажил хийж МХС ТӨХК-р техникийн актаар хүлээлгэн өгөх /Агаараар шилэн кабель оруулахыг хориглоно/ 12 сарын 15 наас худаг сувагчлал хаагдана өмнө амжиж хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Зураг хяналтын тасгийн дарга, Дэд хурандаа **Б.Мягмаржав:**

- Зоорийн давхрын агаар сэлгэлтийн системийг удирдлагын самбарт холбох
- Усны нөөцийн савны хэмжээ хүчин чадал өөрчлөгдсөн, Зохиогч тайлбар ирүүлэх
- Зоорийн давхарт дулаан мэдрэгч систем гүйцээж хийх, 2-10 давхарт
- Давхруудын шатны хонгилд төлөвлөгдсөн гал тэсвэржилтийн зэрэг бүхий хаалга гүйцээж хийх
- Гал түймрийн үеийн утаа зайлуулах болон агаар өгөх системийг бүрэн ажиллагаанд оруулах
- Барилгын 9-10 давхарт өөрчлөлт хийгдсэн
- 11-р давхрын А, В, С, D сууц тагтгүй байна. Зохиогч тайлбар ирүүлэх

Ашиглалтад оруулахаас татгалзаж байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Дутуу заслын ажлуудыг бүрэн дуусгах
- Бетоны бат бэхийн лабораторийн дүгнэлтийг давхар тус бүрээр нь нөхөж үзүүлэх
- Техникийн давхрын дээврийн усны хаялганы буултыг хийж дотуур усны хаялганы хог шүүгч тавих
- Шатны хонгилын цонхны нээлхийд хязгаарлагч хийх
- Лифтний троссны давхар боолтын бэхэлгээг хийх
- Өрлөгөн ханын хаалганы проемд зориулалтын ялуу хэрэглээгүй, зохиогч байгууллага тайлбар АБ ирүүлэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч
Э.Шижиртуяа:

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
- Лифтэнд магадлал хийсэн тухай дүгнэлт техникийн магадлалын акт болон барилга инженерийн байгууламжийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгүүлсэн акт, гүйцэтгэлийн зургийг хувийн хэрэгт хавсаргах
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Дулаан хангамжийн инженер
Х.Очирбат:

- Гадна шугам угсралтын гүйцэтгэлийн фото зураг бэлдэх
- Гадна дулааны худагт стандартын таг суурилуулах
- Шат хийх
- Шугам дулаалах
- Барилгын ачааллаас хамаарч ХХусны өгөхийн д80мм шугам нэвтрүүлэх чадварыг тооцох
- Дулааны узелийн дулааны нацосын хүчин чадлыг дахин тооцох
- Дулааны холболтын цэг өөрчлөх АБ бэлдэх
- ХХусны температурын датчикийг ажиллагаанд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Болормаа:**

- Гадна автомашины зогсоолд ХБИ босоо тэмдэглэгээ хийж дуусгах

- Цахилгаан шатанд харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан давхар зарлагч суурилуулах
- Үйлчилгээний АЦӨ-нүүдэд ХБИ-д зориулсан тоноглол хийх
- Байрлуу орсон пандусыг стандартын дагуу хийх
- В1 давхар буюу грашнаас орц орох хэсгийг шийдэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Конконсалтинг ХХК-ийн архитектор **Б.Эгшиглэн:**

- Дотор заслын ажлыг гүйцээх
- Гранизийг тэгш хэмтэй хийж зай завсарыг силиконоор дүүргэх
- Цонхны амалгааг бат бэх тогтоосон эсэхийг шалгаж дүүргэлтийг сайн хийх
- АЦӨ-ний зай ашиглалтыг тооцон зургийн дагуу байрлуулан тогтоох
- Дутуу хаалга, гаргиз хийх
- Шатны хонгилд усны шугамын хоолойг ус чийгэнд тэсвэртэй будгаар будах
- +30.60 давхрын 8 айлыг галын аюулгүй байдлын норм дүрмээр тагт хийж аврах гарц шат хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч Ви Эйч энд Би ХХК-ийн захирал **Г.Ванчинхүү:**

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч, Ви Эйч энд Би ХХК-ийн захирал **Г.Ванчинхүү:**

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга Байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**


- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт гаргах
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргах
- Тагтны хамгаалалтын босоо холбоосны зайг ойртуулах
- Барилгын хүчин чадлыг батлагдсан баримт бичгийн дагуу тодорхойлж албан тоотоор ирүүлэх. /зохиогч,захиалагч нар/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Ви эйч энд би ХХК-ийн захиалгатай, зоорьтой 10 давхар 1 блок, 28 автомашины дулаан зогсоолтой, 98 байр сууц бүхий аялал жуулчлалын цогцолборыг гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



Тэмдэглэл хөтөлсөн:
Ви Эйч энд Би ХХК-ийн Захирал



(А.Мөнгөн)

(Г.Ванчинхүү)

